



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 355

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 100,703,000.00 (нэг зуун сая долоон зуун гурван мянга) төгрөгийн балансын үнэ, 68,533,986.24 (жаран найман сая таван зуун гучин гурван мянга есөн зуун наян зургаан төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Н.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 07 дугаар сарын 24 ны өдрийн
 365 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, дугаар	Ашиглал- тад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин	Ниссан патрол GRX, УНН 26-05	2011	100,703,000.00	68,533,986.24	32,169,013.76
	Дүн			100,703,000.00	68,533,986.24	32,169,013.76
				(нэг зуун сая долоон зуун гурван мянган)	(жаран найман сая таван зуун гучин гурван мянга есөн зуун наян зургаан төгрөг хорин дөрвөн мөнгө)	(гучин хоёр сая нэг зуун жаран есөн мянга арван гурван төгрөг далан зургаан мөнгө)